



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/431

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Японы Улсын нүдний эмч нарын сайн дурын багийнхан Төв аймагт ажиллах болсонтой холбогдуулан шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зардалд шаардагдах 915,800 (есөн зуун арван таван мянга найман зуу) төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (С.Магнайбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР